



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 06 сарын 12 өдөр

Дугаар A/08

Баянхутаг сум

┌ 5 болон 9 дүгээр ангийн суралцагчдыг ┐
төгсгөх тухай

Монгол улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.3 дахь заалт, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2023-2024 оны хичээлийн жилд тус сургуулийн 9 дүгээр ангийн 6 суралцагч 5 дугаар ангийн 19 суралцагч бага болон суурь боловсролыг бүрэн эзэмшсэн тул 9 дүгээр анги төгсөгчдийг суурь боловсрол, 5 дугаар анги төгсөгчдийг бага боловсрол эзэмшсэнд тооцсугай.

2. Бага болон суурь боловсрол эзэмшсэн суралцагчидтай холбогдох тооцоог 06 дугаар сарын 15-ний дотор хийж дуусгахыг анги удирдсан багш нарт үүрэг болгосугай.

3. Суурь боловсрол эзэмшсэн суралцагчдын гэрчилгээг бичиж олгохыг сургалтын менежер Г.Батбаярт даалгасугай.

ЗАХИРАЛ



Г. ГАНБОЛД